



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 88

Номгон

Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
2013 оны сонгуулийн саналын хуудас устгах  
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.19 дэх заалт, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Сонгуулийн Ерөнхий хорооны 2017 оны 05 дугаар сарын 04-ний 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Төрийн архивт хадгалагдаж байгаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны сонгуулийн саналын хуудсыг холбогдох журмын дагуу устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч-Ц.Дашцэрэн-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн Сонгуулийн хорооны дарга

Нарийн бичгийн дарга-Д.Юндэнбазар-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Олон нийттэй харилцах хэлтсийн дарга, аймгийн аймгийн Сонгуулийн хорооны нарийн бичгийн дарга

Гишүүд: М.Өнөржаргал-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, аймгийн Сонгуулийн хорооны гишүүн

В.Эрдэнэчимэг-Аймгийн Төрийн архивын тасгийн дарга

Б.Батбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн, аймгийн Сонгуулийн хорооны гишүүн

Ц.Бадамгарав-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны архив, бичиг хэргийн ажилтан

2. Саналын хуудас устгасан тухай тэмдэглэл, актыг холбогдох материалын хамт аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын алба, Сонгуулийн Ерөнхий хороонд албан бичгээр хүргүүлэхийг ажлын хэсэг /Ц.Дашцэрэн/-т даалгасугай.

0117215

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР